



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2013 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/291

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын "Журам батлах тухай" 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай" 2010 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 391 дүгээр тушаалын Ганболд овогтой Сэлэнгэд холбогдох хэсгийн "Васеда их сургуулийн магистрантурт" гэснийг "Аояма Гакүин их сургуулийн магистрантурт" гэж, Буджав овогтой Болормаад холбогдох хэсгийн "Английн Бристолын их сургуулийн магистрантурт орон судлалын чиглэлээр" гэснийг "АНУ-ын ДеВрай их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр" гэж, "Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай" 2010 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 568 дугаар тушаалын Жаргалсайхан овогтой Энхбаярт холбогдох хэсгийн "1,5 жилийн хугацаатайгаар" гэснийг "2 жилийн хугацаатайгаар" гэж, "Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" 2011 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 276 дугаар тушаалын Чулуунбаатар овогтой Итгэлд холбогдох хэсгийн "1,5 жилийн хугацаатайгаар" гэснийг "2 жилийн хугацаатайгаар" гэж, "Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай" 2011 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 507 дугаар тушаалын Дэмбэрэлсүрэн овогтой Цэвээндоржид холбогдох хэсгийн "1,5 жилийн хугацаатайгаар" гэснийг "2 жилийн хугацаатайгаар" гэж, "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2012 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А/334 дүгээр тушаалын Даваадорж овогтой Отгончимэгт холбогдох хэсгийн "Дартмоут дэх Массачусетт их сургуулийн" гэснийг "Вашингтоны их сургуулийн" гэж, "Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай" 2012 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн А/381 дүгээр тушаалын Эрдэнэ-Очир овогтой Эрдэнэбаатарт холбогдох хэсгийн "Харвардын их сургуулийн магистрантурт 2 жилийн

хугацаатайгаар” гэснийг “Калифорнийн их сургуулийн докторантурт 3 жилийн” гэж,
 “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2012 оны 7
 дугаар сарын 20-ны өдрийн А/421 дүгээр тушаалын Цогсүрэн овогтой Ивээлд
 холбогдох хэсгийн “Дартмоут дэх Массачусетт их сургуулийн” гэснийг “Массачусеттийн
 технологийн дээд сургуулийн” гэж, “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад
 суралцуулах тухай” 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/59 дүгээр тушаалын
 Дамдиндорж овогтой Дэжидмаад холбогдох хэсгийн “1 жилийн хугацаатайгаар” гэснийг
 “1,5 жилийн хугацаатайгаар” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу
 төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын
 биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус
 тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР